

Улс төр

## "БИДНИЙ ЭЭЛЖ БОЛЛОО. ТҮҮНИЙГ ХҮЛЭЭЖ АВЦГААЯ!"

(1993 оны 1 дүгээр сарын 20-нд АНУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалыг хүлээн авах ёслол дээр Билл Клинтонн хэлсэн үг)

Миний эх орон нэгт иргэдээ !

Энөөдөр бид Америкийн шинэчлэлийн мөн чанарыг ёслол тэмдэглэж байна. Энэ ёслол дүн өвөл болж байна. Гэвч бид хэлж ярьж байгаа үг, дэлхий дахинд харуулж буй нүүр царайгаараа хэврыг авчирч байна.

Дэлхийн ууган ардчилал бүхий оронд дахин мэндчилж буй энэ хавар Америкийг шинээр нээх хүсэл эрмэлзэл, урам зориг бадрааж байна.

Манай төр, улсыг үндэслэн байгуулагчид анх Америкийн тусгаар тогтнолыг дэлхий дахинд, манай зорилгыг бурхны өмнө зоригтой тунхаглахдаа, америк өнө удаан оршин тогтнож өөрчлөгдсөөр байх болно гэдгийг мэдэж байсан бизээ.

Зөвхөн өөрчлөхийн тулд өөрчлөх биш, харин Америкийн туйлын зорилго-амьдрал, эрх чөлөө, аз жаргалтай байхыг сахин хамгаалах шинэчлэл юм. Хэдийгээр бид орчин үетэй зохицон явах боловч манай зорилго бол цаг хугацаагүй алба мөн.

Америкчуудын үе бүхэн америк хүн ямар байх ёстойг өөрсдөө тодорхойлох учиртай.

Америкийн тусын тулд хагас зуун жил хүчин зүтгэсэн миний өмнөх Ерөнхийлөгч Бушид би ард түмнийхээ нэрийн өмнөөс баяр хүргэж байна. Түүнчлэн мятаршгүй зориг, амь бие үл хайрлах зүтгэлээрээ хямрал, фашизм, коммунизмыг ялан дийлсэн сая сая эрэгтэй, эмэгтэй хүмүүст би талархал илэрхийлж байна.

Хүйтэн дайны сүүдэрт өсөж бойжсон үеийнхэн өнөөдөр эрх чөлөөний нарны элчинд бүлээцсэн дэлхийд шинэ хариуцлагатай үүрэг хүлээн авч байгаа хэдий ч урьдын дайсагнал, шинэ зөрчил замалхийлсээр байна.

Бусадтай зүйрлэшгүй хөгжил дэвшилд өсөж бойжсон бид эдүгээ дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засгийг өвлөн авч байгаа боловч аж ахуйн урагшгүйтэл, зогсонги цалин хөлс, улам нэмэгдсээр буй тэгш бус байдал, манай хүн амын доторхи гүнзгий ялгарлын улмаас эдийн засаг сульдан доройтож байна.

Миний одоо өргөх гэж байгаа ачлал тухайн үедээ Жорж Вашингтоны өргөж байсан тангаргийн тухай мэдээг мориор хуурай газар туулан, завиар тэнгис далай гатлан удаан хугацаанд хүргэж байсан бол өнөөдөр энэ ёслолын дүрс, дуу хоолойг дэлхийн өнцөг булан бүрт нэвтрүүлж, хэдэн тэрбум хүмүүс шууд харж сонсож байгаа бизээ.

Орчин үед харилцаа холбоо, арилжаанаймаа дэлхий дахины шинжтэй болж, хөрөнгө оруулалт үргэлжийн хөдөлгөөнд орж, технологи гайхамшигтай хөгжиж, сайн сайхан амьдрах эрмэлзэл бүх нийтийн тэмүүлэл болж байна. Бид дэлхий дахины улс түмэнтэй тайван замаар уралдан өөрсдийнхөө хөдөлмөрөөр амьдарна.

Нөлөө бүхий айхавтар хүч дэлхий дахиныг донсолгон өөрчилж буй өнөө үед хамгийн тулгамдсан асуудал бол бид өөрчлөлтийг хор биш, хоолоо болгож чадах эсэхэд оршино.

Энэ шинэ дэлхийд уралдаж, түүнд ялах чадвартай болохыг сая сая америкчуудын амьдрал аль хэдийнээ харуулсан юм. Гэвч олонхи хүмүүс их ажиллан, бага хөлс авч, зарим нь бүр ажиллаж чадахгүй болж, эмчилгээний өртөг айл өрхийг тарчигдуулан, том жижиг олон тооны үйлдвэрийн газар дампуурах аюулд орж, гэмт хэргийн аймшиг хуулиа сахьдаг иргэдийн эрх чөлөөг хохироон, үй олон сая хүүхэд бидний уриалж буй өөдрөг амьдралыг төсөөлж чадахгүй байгаа явдал бол бид өөрчлөлтийг хоолоо болгож чадаагүйн илрэл мөн.

Бид хагуухан үнэнтэй учирч, шийдэмгий алхам хийх ёстой гэдгээ мэдэж байна. Гэтэл бид одоог хүртэл тэгэж чадсангүй. Харин ч бид урсгалаар явж, ингэснээр нөөц бололцоогоо шамшигдуулж, эдийн засгаа тамирдуулан, итгэл найдвараа алдахад хүрч байлаа.

Хэдийгээр манай зорилт хүнд ч гэсэн, бидэнд бас хүч чадал бий. Америкчууд бол угаасаа зүгээр суудаггүй, эрэлч, итгэж болох хүмүүс билээ. Бид өмнөх үеийнхнийхээ мөрөөдөл, гэрээсийг биелүүлэх явдлыг өнөөдрийн зорилт болгох ёстой.

Америкийн хувьсгалаас иргэний дайн, их хямрал, иргэний эрхийн хөдөлгөөн хүртэл манай ард түмэн эдгээр хямралыг гэтлэн давахад зориг төгөлдөр явж, манай түүхийг бүтээхийн түшиг тулгуур, эзэд ялагт болж байсан юм.

Уас үндэстнийхээ гал голомтыг сахин хамгаалж байхын тулд бид үе үе дорвитой өөрчлөлт хийж байх хэрэгтэй гэдэгт Томас Жефферсон их ач холбогдол өгч байлаа. Иймээс миний эх орон нэгт иргэд ээ, бидний ээлж боллоо, түүнийг хүлээж авцгаая!

Манай ардчилал зөвхөн дэлхийн дахинд дуудлага болох төдийгүй манай өөрийн шинэчлэлийн хөдөлгүүр нь байх ёстой. Америкийн хувьд юу эвэ байна, түүнийг засна гэхгүй ээ. Үүнд буруу байхгүй.

Ийнхүү өнөөдөр бид зогсонги байдал, урсгалаар явах үеийг эцэс болгохоос ёслол төгөлдөр амлаж байгаагаар Америкийн шинэчлэлийн шинэ үе эхлээд байна.

Америкийг өөрчилж шинэчлэхийн тулд бид хатан зоригтэй байх ёстой. Урьдах иль ч үеийнхний хийж байгаагүй юмыг бид хийх учиртай. Бид өөрсдийнхөө ард иргэд, тэдний ажлын байр, ирээдүйг илүү анхаарч хөрөнгө оруулалт хийхийн зэрэгцээ асар их өрийг багасгах ёстой. Боломж бүрийн төлөө өрсөлдөж байх тийм л орчинд бид үүнийг хийх болж байна.

Энэ бол амархан ч зүйл бишээ, биднээс тун шургуу зүтгэхийг шаардана. Гэвч бид өөрсдийгөө золионд гаргалгүйгээр үүнийг манай тусын тулд хийж болно. Гэхдээ бүр сайн хийж болно. Үр хүүхдээ гэр бүл тэтгэгдийн адил улс орноо бид тэтгэх ёстой.

Манай төр, улсыг үндэслэн байгуулагчид хойч үеийнхнийхээ төлөө анхаарч байжээ. Бид ч тэднээс дутуугүй зүйл хийж болно. Бага хүүхдийн унтахаар үүрэглэн буй нүдийг ажигласан хэн боловч хойч үе гэж юу бслохыг төсөөлнө. Хойч үе гэдэг бол залгамжлах үр удам мөн бөгөөд бид тэдний төлөө санаа зовж, тэднээс эх дэлхийгээ эзэлдэн аваад, тэдний өмнө ариун үүрэг хүлээж байгаа юм.

Америктаа сайн хийж чаддаг юмыг бид хийх ёстой: хүн бүрт илүү боломж бүрдүүлж өгөөд хүн бүрээс хариуцлага шаардана.

Юу ч хийгээгүй байж засгийн газраас болон бие биенээсээ ямар нэг юм хүлээж суудаг муу зуршлыг арилгах цаг болжээ. Бүгдээрээ өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ төлөө төдийгүй манай нийгэм, улс орны төлөө улам их хариуцлагатай байцгаая.

Америкийг шинэчлэхийн тулд бид ардчиллаа төгөлдөржүүлэх хэрэггүй.

Соёл иргэншил мандсан цагаас хойш энэ үнэт баялаг маань бусад баялгын нэгэн адил нууц явуулга, төсөөлөл таамаглалын хэрс байн байн болж байна. Хөлсхүчээ шавхан ажиллаж, амьдралыг залгуулан энэрэл хайр үзүүлж биднийг энд илрүүлсэн олон түмнээ огоордог эрх мэдэл бүхий албан тушаалтнууд хэн үлдэв, хэн халагдэв, хэн албан тушаалд дэвшив, хэн буурав гэж эцэс төгсгөлгүй ярьж шаналан, албан тушаалын төлөө арга заль хэрэглэж явдаг байна.

Америкчууд сайн юм хийж чадах хүмүүс бөгөөд өнөөдөр ч энэ хотод сайн юм хийхийг хүсэж байгаа хүмүүс байж байна. Иймээс эрх мэдэл, албан тушаал цаашид хэзээ ч хүмүүсийн дуу хоолойг хавчиж хаахгүй байлгахын тулд манай боллогод өөрчлөлт хийх талаар шийдвэр гаргацгаая гэж би энд та бүхэнд хэлэх байна. Бид Америкийн эмзэг зүйлийг мэдэрч, ирээдүйн төлөвийг харж чадахын тулд хувийн ашиг хонжоо хөөцөлдөхөө орхицгооё.

Засгийн газраа Франклин Рузвельтийн хэлснээр "Эрс шийдэмгий, тогтвортой сорилтын" газар, бидний өчигдрийн биш, маргаашийн өдрийг илэрхийлсэн газар болгох талаар шийдвэр гаргацгаая.

Ард түмэнд харьяалагддаг дээрх баялагийг түүнд нь эгүүлэн өгцгөө

Америкийг өөрчлөн шинэчлэхийн тулд бид гадаадад болон түүнчлэн дотоодод олон ээдрээтэй асуудалтай тулгарах болно. Дэлхийн эдийн засаг, хүрээлэн байгаа орчин, ДОХ-ын өвчин, дэлхий дахинд зөвсгээр хөөцөлдөж буйн аль нь ч бид бүгдэд нөлөөлж, гадаадын, дотоодын гэж ялгах аргагүй болоод байна.

Өнөөдөр хуучин дэг улиран одож, шинэ дэлхий маань нэлээд чөлөөтэй болж байгаа боловч бас тийм ч тогтвортой биш байна. Коммунизмын сүйрэл нь хуучин өс, шинэ аюулыг бий болголоо. Америк дэлхийг тэргүүлэх талаар их чармайлт гаргасан бөгөөд үүнийг үргэлжлүүлэн хийх нь тодорхой.

Америк дотооддоо өөрчлөлт хийж байхдаа ч бид энэ шинэ дэлхийн ээдрээтэй асуудлуудаас зайлсхийхгүй, аливаа боломж ашиглах завшааныг ч алдахгүй байх болно. Бид өөрчлөлтөд дарагдчихгүйн тулд найз нөхөд болон холбоотнуудтайгаа хамтран түүний чиг баримжааг тогтоох талаар ажиллана.

Хэрвээ манай амин эрх ашгийг хөндөх буюу олон улсын хамтын нийгэмлэгийн хүсэл, эрмэлзлийг хайхрахгүй тохиолдолд бид өр нь болж өгөөл энхийн дипломат аргаар, шаардлагатай гэж үзвэл хүч хэрэглэх аргаар

хандана. Персийн булан, Сомали болон бас бус газар байрлан манай улсын алба хашиж буй эрэлхэг америкчууд бол бидний эрс шийдэмгий байхын илэрхийлэл юм.

Гэвч манай агуу их хүчин чадал нь эдүгээ олон оронд шинэ гэгдэж буй манай үзэл санааны утга учирт оршино. Дэлхий дахинд манай үзэл санааг таалж баяр хүргэж байгааг бид мэдэрч байна. Ардчилал, эрх чөлөөг эрхэмлэн зорьж буй тив бүрийн хүмүүстэй бидний итгэл найдвар, зүрх сэтгэл, гар хамт байна. Тэдний үйл хэрэг бол Америкийн үйл хэрэг мөн.

Бидний өнөөдөр ёслол тэмдэглэж байгаа шинэчлэл хийхийг америкийн ард түмэн шаардсан юм. Та нар дуу хоолойгоо нэгэн зэрэг өргөсөн. Та нарын санал нэгдэж түүхэнд орлоо. Ингэснээр та нар Конгресс, Ерөнхийлөгчийн засаглалын нүүр царайг улс төрийн үйл явцтай нь өөрчилсөн. Эх орон нэгт америкчууд та нар л хаврын урь оруулсан. Одоо биднээс шаардаж буй ажлыг хийх л үлдлээ.

Би албаныхаа бүхий л хүмүүстэйгээ одоо тэр ажилд орлоо. Конгрессыг надтай хамтарч ажиллахыг би хүсэж байна. Ер нь Ерөнхийлөгч, Конгресс, Засгийн газрын аль нь ч энэ үүрэг даалгаврыг дангаараа өөртөө авч дийлэхгүй. Миний эх орс нэгт америкчууд та нар ч манай шинэчлэлд бас өөрсдийн үүргийг гүйцэтгэх ёстой. Би залуу америкчуудын шинэ үеийг зөвж зүдэрсэн хүүхдүүдэд туслан, тэдний их гачигдалтайд нь энэрэл хайрлаж, манай орхигдсон энэ хэсэгтэй биднийг холбож өгөх талаар өөрсдийнхөө ухамсраар түргэн шуурхай ажиллахыг уриалж байна. Ингэж халамжлуулбал зохих, одоогоор арай балчир олон сая хүүхэд бас байгаа гэж бодоход л бидний хийх ажил үнэхээр их байна.

Ингэж ажилласнаараа бид бие биестээ хэрэгтэй, бие биесийгээ халамжлах ёстой гэсэн энгийн боловч хүчиг үнэнийг мэдэж авна. Өнөөдөр бид Америкийг ёслол тэмдэглэж байгаагаар үл барам өөрсдийгөө Америкийн уламжлалт үзэл санаанд дахин зориулж байна.

Уг үзэл санаа Америкийн хувьсгалаар төрөөд хоёр зуун жилийн урлдааны явцад өөрчлөгдөн шинэчлэгдэж ирсэн юм. Энэ үзэл санаа бидний азтай ч бай, азгүй ч бай, хувь тавилангаар бие биетэйгээ хамт байх учиртай гэдэг танин мэдэхүйг бататгасан юм. Манай улс олон янзын хүмүүс, ястан үндэстнээс бүрэлдэн оршиж, тэдгээрийн эв нэгдэлтэй байхын маш нарийн хэмжүүр бол ийм итгэлийг бий болгож өөд татсан дээрхи үзэл санаа юм. Энэ үзэл санаа нь Америкийн урт хугацааны баатарлаг замнал ямагт урагшлан өөдрөг байх ёстой гэсэн итгэлийг төрүүлж байна.

Америкийн эх орон нэгт иргэд ээ, ийнхүү XX1 зууны босгон дээр цөмөөрөө эрч хүч, итгэл найдвар, сахилга баттайгаар ажлаа эхэлцгээж,

бидний ажлын эцсийн үр дүн гартал ажиллацгаая. "Сайн үйлсэд цуцалтгүй байцгааж, бид юу ч тохиолдсон ургацаа хугацаанд нь хурааж авна" гэж ариун сударт байдаг шүү дээ.

Ёслолын энэхүү бахдам өндөрлөгөөс бид бууж олон түмэнтэйгээ ажиллаж дуудлага сонсож байна. Бид бүрэн дуу сонслоо. Бид харуулаа ч солилоо. Одоо бид бүхэн тохиролцсныхоо дагуу бурхны ааралаар тэр дуудлаганд хариулцгаах ёстой.

Та нарг баярлалаа, та бүхнийг бурхан ивээх болтугай.